

Дундговь аймаг дахь
Төрийн аудитын газар



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“УЛСЫН ТӨСВИЙН 2025 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН”-Д ХИЙСЭН
ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: /ГАГ-2026/05-ШТА-НА/

Дундговь дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох Утас: 70592439
Аудитын менежер: Т.Батсайхан Утас: 70592225
Цахим хаяг: Dundgovi@audit.gov.mn
Ахлах аудитор: О.Баярсайхан
Аудитор: Л.Уранбилэг
Аудитор: Г.Үүрийнтуяа
Утас: 7059-2208

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу.
Цахим хуудас: www.audit.mn

<p><u>Тайланг бэлтгэсэн:</u></p> <p>Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар</p> <p>Дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох</p> <p>Аудитын менежер</p> <p>Т.Батсайхан</p> <p>Ахлах аудитор</p> <p>О.Баярсайхан</p> <p>Аудитор</p> <p>Л.Уранбилэг</p> <p>Г.Үүрийнтуяа</p> <p>Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70592208 дугаарын утас, 70593208 дугаарын факсаар харилцана уу.</p> <p>ХАЯГ:</p> <p>Сайнцагаан сум 7-р баг, Нутгийн удирдлагын ордон, 213 тоот</p> <p>2026 оны 4 дүгээр сар</p>	<p>Тайлан баталгаажуулах тушаал</p> <p>Товчилсон үгс</p> <p>Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй</p> <p>Дүрслэлийн товчъёг</p> <p><u>Бүлэг А. Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө бодит хэрэгцээ шаардлагад үндэслэн эрэмбэлж, холбогдох хууль, журамд нийцүүлэн шаардлага хангуулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулах нь зүйтэй.</u></p> <p><u>Бүлэг Б. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд ийнээр хэрэгжих төсөл, арга хэмжээний эрх шилжигч ирээгүй тул худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаагүй байна.</u></p> <p><u>Бүлэг В. Улсын төсвийн хөрөнгөөр бий болсон арга хэмжээг хугацаанд нь ашиглалтад оруулж байгаа хэдий ч хөрөнгийг бүртгэх ажил удаашралтай байна.</u></p> <p>Дүгнэлт</p> <p>Зөвлөмж</p> <p>Шалгагдагч байгууллагын санал тайлбар</p> <p>Хавсралтууд</p>	<p>2</p> <p>3</p> <p>4-6</p> <p>7</p> <p>8-11</p> <p>11</p> <p>11-19</p> <p>20</p> <p>21</p> <p>22</p> <p>23</p>
---	---	--



Тайлан баталгаажуулах тушаал



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2026 оны 04 сарын 09 өдөр

Дугаар Н/аг

Мандалговь

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/102 дугаар тушаалаар батлагдсан “Аймаг нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх үүрэг”-ийн 1.1, 1.4 Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18 дугаар зүйлийн 9-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан (ГАГ-2026/05-ШТА-НА)-г нэгдүгээр, аудитаар илэрсэн зөрчлийн жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. “Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг Үндэсний аудитын газар, аймгийн Засаг дарга, ИТХ-ын даргад тус тус хүргүүлсүгэй.

3. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг “Төрийн аудитын тухай хууль”-ийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангуулан, үр дүнгийн талаар заасан хугацаанд Төрийн аудитын газарт хариу ирүүлэхийг Дундговь аймгийн Засаг дарга (С.Мөнхчулуун)-д зөвлөсүгэй.

Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон 2026 оны 4 дүгээр улиралд танилцуулахыг Аудитын хоёрдугаар нэгжийн ахлах аудитор (О.Баярсайхан)-д үүрэг болгосугай.



Р.МӨНХТОГТОХ

4826010018

ТОВЧИЛСОН ҮГС

АДБОУБ	Аудитын дээд байгууллагуудын олон улсын байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АЗД	Аймгийн Засаг дарга
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ЗДҮАХ	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТАХ	Төсөл, арга хэмжээ
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.5 дахь зүйлийг үндэслэн мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2025 оны 25 дугаар тогтоолын дагуу “Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамжаар гүйцэтгэлийн аудит хийлээ.

Аудитын зорилт:

Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэсэн. Үүнд:

- ✓ Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг оновчтой төлөвлөсөн эсэх;
- ✓ Төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулж хяналт тавьсан эсэх;
- ✓ Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь гүйцэтгүүлж төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэх.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт:

Дараах хууль эрх зүйн актын холбогдох заалтуудыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

- ✓ Аудитад дараах шалгуур үзүүлэлтүүдийг ашиглана. Үүнд:
- ✓ Төсвийн тухай хууль;
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- ✓ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль;
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- ✓ Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт өөрчлөлт;
- ✓ Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль;
- ✓ Барилгын тухай хууль;
- ✓ Эрчим хүчний тухай хууль;
- ✓ Авто замын тухай хууль;
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- ✓ “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого;
- ✓ Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”;
- ✓ Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр;
- ✓ Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай;
- ✓ Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”;

Аудитын хамарсан хүрээ:

- ✓ Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар";
- ✓ Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”;
- ✓ Сангийн сайдын 2023 оны А/261, 2025 оны А/106 дугаар тушаалаар тус тус баталсан “Харьцуулалтын аргаар үйлчилгээ авах тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг”;
- ✓ Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам болон холбогдох аргачлалууд”;
- ✓ Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжүүд;
- ✓ Барилга байгууламжийн үнэ бүрдэл, төсөв зохиох норм, дүрэм, стандарт;
- ✓ Батлагдсан зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэл, магадлалын ерөнхий дүгнэлт, ажил гүйцэтгэх гэрээ болон холбогдох бусад эрх зүйн актууд.

Аудитыг Дундговь аймагт 2025 онд улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалт төсөл, арга хэмжээний төлөвлөлт, ТЭЗҮ, зураг төсөл, магадлалын дүгнэлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, түүний хэрэгжилт, олгосон санхүүжилт, эрх бүхий байгууллагаас хяналт хийсэн ажлын тайлан болон төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнгийн хүрээнд үндэслэн хийсэн.

Аудитын явцад объект дээр ажиллаж, барилга байгууламжийн ажлын бодит гүйцэтгэлийг газар дээр нь шалгасан.

Аудитад улсын төсвөөс 2025 онд санхүүжүүлсэн, төсвийн ерөнхийлөн захирагчид эрх шилжин хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын 4 төсөл, арга хэмжээний хэрэгжилт болон эдгээр төсөл, арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллагууд, төсөл, арга хэмжээг гүйцэтгэгч нарын холбогдох үйл ажиллагааг хамруулав.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу

аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ хийх, харьцуулах, тулган баталгаажуулах, түүвэрлэлт хийх зэрэг судалгааны арга зүйг ашиглан аудитын хөтөлбөрт дурдсан хугацаанд нотлох зүйл цуглуулж, аудитын дүгнэлт, зөвлөмжийг боловсруулсан.

Аудитын гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох хянан удирдаж, аудитын менежер

*Аудит хийх багийн
бүрэлдэхүүн, хугацаа:*

Т.Батсайхан үе шатны чанарын хяналт хэрэгжүүлэн, ахлах аудитор О.Баярсайхан, аудитор Л.Уранбилэг, Г.Үүрийнтуяа нар 2026 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс 2026 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийг дуустал хугацаанд аудитыг хийж гүйцэтгэлээ.

Аудитын дүн

Аудитаар нийт 1,777.6 сая төгрөгийн зөрчил илрүүлж, зөрчлийг арилгуулахаар аймгийн Засаг даргад 3 зөвлөмжийг хүргүүллээ.

Үндсэн мэдээлэл

Дундговь аймагт 2025 онд улсын төсвийн хөрөнгөөр шинээр эхлэх, эрх шилжиж ирсэн төсөл, арга хэмжээ байхгүй бөгөөд өмнөх оноос шилжсэн 4,917.0 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 4 төсөл, арга хэмжээ хэрэгжсэн байна. Дээрх 4 төсөл, арга хэмжээнд 4,696.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. Үүнд:

1. Соёлын төвийн барилга, 240 суудал /Дундговь, Цагаандэлгэр сум/;
2. 240 суудалтай Соёлын төвийн барилгын гадна инженерийн шугам сүлжээ, гадна талбайн тохижилтын угсралтын ажил /Дундговь, Цагаандэлгэр сум/;
3. Төрийн нэг цэгийн үйлчилгээний төвийн барилга /Дундговь, Сайнцагаан сум/;
4. Соёл, урлагийн цогцолборын барилга /Дундговь, Өндөршил сум/ тус тус байна.

Хүснэгтийн товьёг

<i>№</i>	<i>Тайлбар</i>	<i>Хуудасны дугаар</i>
<i>Хүснэгт 1</i>	<i>УТХО-аар 2025 онд хэрэгжүүлэхээр Сангийн яаманд хүргүүлсэн төсөл, арга хэмжээний саналыг сумд болон салбараар харууллаа</i>	<i>8</i>
<i>Хүснэгт 2</i>	<i>Төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан болон уялдсан байдал</i>	<i>9</i>
<i>Хүснэгт 3</i>	<i>Төлөвлөсөн төсөл, арга хэмжээний холбогдох шинжилгээ, тооцоолол хийсэн байдал</i>	<i>9-10</i>
<i>Хүснэгт 4</i>	<i>Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022-2025 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний санал, батлагдсан байдал</i>	<i>10</i>
<i>Хүснэгт 5</i>	<i>Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээнд тавигдах шаардлагыг хангасан байдал</i>	<i>11</i>
<i>Хүснэгт 6</i>	<i>2025 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний хэрэгжүүлэх хугацаа, хэрэгжсэн байдал, гэрээний дүн</i>	<i>12</i>
<i>Хүснэгт 7</i>	<i>2025 онд олгосон санхүүжилтийн мэдээлэл</i>	<i>13</i>
<i>Хүснэгт 8</i>	<i>Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд тусгагдсан шилжих төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн байдал</i>	<i>15</i>
<i>Хүснэгт 9</i>	<i>Зохиогчийн хяналтыг хэрэгжүүлсэн байдал</i>	<i>17</i>



БҮЛЭГ А. Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө бодит хэрэгцээ шаардлагад үндэслэн эрэмбэлж, холбогдох хууль, журамд нийцүүлэн шаардлага хангуулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулах шаардлагатай байна.

A.1 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл, арга хэмжээг хөгжлийн бодлогын баримт бичигтэй үялдүүлэн, бодит нөхцөл байдлыг үнэлж, хэрэгцээ шаардлагаар эрэмбэлж хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд 76,722.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 8 төсөл, арга хэмжээг шинээр хэрэгжүүлэх саналыг бэлтгэн төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем /pimis.publicinvestment.gov.mn/-д оруулж, Сангийн яаманд хүргүүлсэн байна.

Хүснэгт 1: УТХО-аар 2025 онд хэрэгжүүлэхээр Сангийн яаманд хүргүүлсэн төсөл, арга хэмжээний саналыг сумд болон салбараар харууллаа.

Салбар болон сумын нэр	Адаацаг		Дэрэн		Сайнцагаан		Хулд		Нийт	
	Тоо	Төсөв	Тоо	Төсөв	Тоо	Төсөв	Тоо	Төсөв	Тоо	Төсөв
Боловсрол	1	3,000.0					1	2,589.6	2	5,589.6
Дэд бүтэц					3	54,804.0			3	54,804.0
Соёл, спорт					1	11,057.0			1	11,057.0
Төрийн захиргаа			1	2,272.3					1	2,272.3
Эрүүл мэнд			1	3,000.0					1	3,000.0
Дүн	1	3,000.0	2	5,272.3	4	65,861.0	1	2,589.6	8	76,722.9

Эх сурвалж: Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтэс

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээг байршлаар авч үзвэл Адаацаг, Хулд сумдад 1, Дэрэн суманд 1, аймгийн төв буюу Сайнцагаан суманд байршилтай 4 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн бол бусад сумдад төлөвлөөгүй байна. Төсөвт өртгийн хувьд хамгийн их буюу 71.4 хувь нь ус, дулаан хангамжийг сайжруулах дэд бүтцийн 3 төсөл, арга хэмжээ, 14.4 хувь нь соёл урлагийн салбарын 1 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн бол 3 хувь нь төрийн захиргааны салбарын 1 төсөл, арга хэмжээ байна.

Аймгийн дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан болон нэн тэргүүний шаардлагатай хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг тодорхойлж, нэгтгэж эрэмбэлсэн судалгаа, төлөвлөлт байхгүй байна. Аймгийн хэмжээнд нэгдсэн бодлого төлөвлөгөөгүйгээс сум, байгууллага тус бүр зураг, төсөв хийлгэж байгаа нь 2 жилийн хугацаа өнгөрч төсвөө дахин шинэчлэх шаардлага үүсэж, үр ашиггүй зардал гарах эрсдэлтэй байна.

Иймд аймгийн хэмжээнд төсвийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгцээ шаардлагыг тодорхойлон нэн тэргүүний ач холбогдлоор эрэмбэлж, үе шаттай хэрэгжүүлэхэд анхаарах шаардлагатай байна.

A.1.1 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээ нь аймгийн дунд хугацааны бодлогын баримт бичгийн зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээ нь аймгийн дунд хугацааны бодлогын баримт бичгийн зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн байна. Энэ нь Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3.1.4.1¹-д заасантай нийцэж байна.

Хүснэгт 2: Төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан болон уялдсан байдал

¹ 3.1.4.1.хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан болон уялдсан байдал;

№	Төсөл, арга хэмжээний нэр	2021-2025 оны үндсэн чиглэлд тусгагдсан эсэх	2024-2028 оны ЗДҮАХ-т тусгагдсан эсэх
1	Дулааны станцын 2-р хэлхээний гадна дулааны шугамын ажил /Дундговь, Сайнцагаан сум/	Тийм	Тийм
2	Дотуур байрны барилга, 80 ор /Дундговь, Адаацаг сум/	Тийм	Тийм
3	Аймгийн төвийн 6.4 км үерийн хамгаалалтын далангийн барилга, байгууламжийн угсралтын ажлыг үргэлжлүүлэх /Дундговь, Сайнцагаан сум/	Тийм	Тийм
4	Засаг даргын Тамгын газрын барилга /Дундговь, Дэрэн сум/	Үгүй	Тийм
5	Эрүүл мэндийн төвийн барилга, 10 ор /Дундговь, Дэрэн сум/	Үгүй	Тийм
6	Соёлын төв, хүүхдийн театрын барилга, 400 суудал /Дундговь, Сайнцагаан сум/	Тийм	Тийм
7	Олгойн говийн цэвэр усны 3.5 км дан цэвэр усны шугамыг хос болгох ажил /Дундговь, Сайнцагаан сум/	Тийм	Үгүй
8	Цэцэрлэгийн барилга, 150 суудал /Дундговь, Хулд сум/	Тийм	Тийм

Эх сурвалж: Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтэс, бодлогын баримт бичгүүд

Төлөвлөсөн 8 төсөл, арга хэмжээний 75.0 хувь нь “Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д, 87.5 хувь нь “Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр”-т тусгагдсан, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих төсөл, арга хэмжээг төлөвлөжээ.

А.1.4 Барилга, байгууламжийн 1 төсөл, арга хэмжээний эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол, урсгал зардлыг тооцоогүй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системээр төлөвлөж байгаа бөгөөд аймгийн ЗДТГ-ын хөрөнгө оруулалт хариуцсан нэгжийн ахлах мэргэжилтэн төслийн саналыг сум, байгууллагаас авч нэгтгэн уг системд мэдээллийг оруулан эрэмбэлж үнэлэн харьяа яам руу илгээж байна.

Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 8 төсөл, арга хэмжээний 1 төсөл, арга хэмжээний эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлын шинжилгээ, үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардлын тооцооллыг хийгээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 29¹ дүгээр зүйлийн 29¹.2.4² дэх хэсэгт заасан шалгуурыг хангахгүй байна. Мөн Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 2.3.1.3³-т заасан аймгийн Засаг даргын чиг үүргийг хэрэгжүүлэхгүй байна.

Хүснэгт 3: Төлөвлөсөн төсөл, арга хэмжээний холбогдох шинжилгээ, тооцоолол хийсэн байдал

Салбар	Эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлын шинжилгээтэй эсэх	
	Тийм	Үгүй
Боловсрол	1	1
Дэд бүтэц	3	
Соёл, спорт	1	
Төрийн захиргаа	1	
Эрүүл мэнд	1	
Дүн	7	1

Эх сурвалж: Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтэс

Цаашид шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний саналд үндсэн хөрөнгийн ашиглалттай

² 29.2.4. урсгал зардал гарах төслийн урсгал зардлыг тооцсон байх;

³ 2.3.1.3.төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний саналд үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэр зэрэг холбогдох тооцоог хавсаргаж, төсөвт нөлөөлөх ачааллын талаарх дүгнэлтийг гаргасан байх;

холбоотой урсгал зардал, орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэр зэрэг холбогдох тооцоог хийх шаардлагатай байна.

A.2 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналд төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл хүргүүлэх нь бодлогын баримт бичигт тусгагдсан төсөл, арга хэмжээ хэрэгжихгүй байх эрсдэлтэй байна.

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчаас улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтаар аймагт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад 8 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр санал хүргүүлсэн нь өмнөх онуудаас тооны хувьд буурсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний тоо буурсан нь төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем Барилгын хөгжлийн төвийн барилга байгууламжийн зураг, төслийн магадлалын дүгнэлтийн мэдээлэлтэй тулган баталгаажуулдаг буюу шаардлага хангаагүй төслийн мэдээллийг системд оруулах боломжгүй болсонтой холбоотой байна.

Хүснэгт 4: Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022-2025 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний санал, батлагдсан байдал:

Он	Нийт санал хүргүүлсэн төсөл, арга хэмжээний тоо	Батлагдсан ТАХ-ний тоо	Үүнээс:	
			Санал хүргүүлсэн	Санал хүргүүлээгүй
2022	28	14	11	3
2023	28	0	0	0
2024	24	20	9	11
2025	8	1	0	1

Эх сурвалж: Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтэс, УТХО-д 2023, 2024, 2025 онд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангаас.

Хүснэгтээс харахад 2022-2024 онд нийт 80 төсөл, арга хэмжээний саналыг хүргүүлж, аймгаас хүргүүлсэн 20 ажил батлагдаж байсан бол 2025 онд 8 хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний саналыг Сангийн яаманд хүргүүлж, нэг ч төсөл, арга хэмжээ батлагдаагүй байна. Энэ нь дараа онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний бэлтгэлийг хангахгүй байгаатай холбоотой байна.

A.2.1 Төлөвлөсөн төсөл, арга хэмжээний 37.5 хувь нь магадлалын дүгнэлт гарснаас хойш гурван жил өнгөрсөн төсөл, арга хэмжээг төлөвлөжээ.

Төсвийн тухай хууль болон Засгийн газрын 2023 оны 278 дугаар тушаалаар батлагдсан журамд төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд тавигдах шаардлагыг хангасан төслийг төлөвлөж, үнэлж, эрэмбэлэхээр зохицуулсан байдаг. Гэвч улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 8 төсөл, арга хэмжээний 25 хувь нь магадлалаар баталгаажсан зураг төсөвгүй, 37.5 хувь нь магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажсанаас хойш 3 жилийн хугацаа өнгөрсөн зураг, төсөлтэй ажлыг төлөвлөсөн байна.

Хүснэгт 5: Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээнд тавигдах шаардлагыг хангасан байдал:

Салбар	Зураг төсөвтэй эсэх		Магадлалын ерөнхий дүгнэлтийн мэдээлэл		Сүүлийн 2 жилийн дотор хийгдсэн магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажсан зураг, төсөвтэй эсэх
	Тийм	Үгүй	Огноо	Дугаар	
Боловсрол	1	1	2023.01.27	0097/2023	Тийм
Дэд бүтэц	2	1	2024.11.21, 2023.03.31	1016/2024, 351/2023	Тийм
Соёл, спорт	1		2021.12.10	1987/2021	Үгүй
Төрийн захиргаа	1		2021.06.29	845/2021	Үгүй
Эрүүл мэнд	1		2021.06.28	234/2021	Үгүй

Эх сурвалж: Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтэс

Төлөвлөж Сангийн яаманд хүргүүлсэн төсөл, арга хэмжээнээс Адаацаг сумын “Дотуур байрны барилга”, “Аймгийн төвийн 6.4 км үерийн хамгаалалтын далангийн барилга, байгууламжийн угсралтын ажлыг үргэлжлүүлэх” барилга, байгууламжийн 2 төсөл магадлалаар баталгаажсан зураг төсөлгүй, аймгийн төвийн “Хүүхдийн театрын барилга”, Дэрэн сумын “Засаг даргын Тамгын газрын барилга”, “Эрүүл мэндийн төвийн барилга”-ын төслүүд сүүлийн 2 жилийн хугацаанд хийгдсэн магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажсан зураг, төсөвгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 29¹.2.2⁴, “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3.2.2.2⁵ дох заалттай нийцэхгүй байна.

A.2.3 (A.2.4) Шинээр хэрэгжүүлэхээр санал хүргүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжих хугацаа болон санхүүжилтийн хуваарийг төлөвлөлтийг шаардлагыг хангаж төлөвлөжээ.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө шинээр эхлэх барилга, байгууламжийн төслийн хэрэгжих хугацааг 3 жилээс ихгүй байхаар, санхүүжилтийг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү байхаар тооцож цахим системдээ мэдээллийг оруулан илгээсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 29.3.5⁶ дахь заалттай нийцэж байна.

A.2.5 Төсөл, арга хэмжээг хэрэгжүүлснээр хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг хэмжигдэхүйц байдлаар тодорхойлжээ.

Аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, жилийн хөгжлийн төлөвлөгөө, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг дунд хугацааны бодлогын баримт бичигт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн барилга, байгууламжийн 8 төсөл, арга хэмжээг тусгасан байна.

Төсөл, арга хэмжээг хэрэгжүүлснээр зорилтыг үнэлэх шалгуур үзүүлэлт, хүрэх түвшнийг тодорхойлохдоо барилгын ажлын гүйцэтгэлээр, баригдсан барилга, байгууламжийн тоогоор хэмжихээр тодорхойлсон байна. Энэ нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.22⁷, 4.1.23⁸-т заасантай нийцэж байна.



БҮЛЭГ Б. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний эрх шилжиж ирээгүй тул худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаагүй байна.

Аймгийн Засаг даргад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний эрх шилжиж ирээгүй тул худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаагүй байна. Харин өмнөх оноос шилжин хэрэгжих барилга, байгууламжийн 4 төсөл, арга хэмжээг 4,917.0 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд тусгажээ.



БҮЛЭГ В. Улсын төсвийн хөрөнгөөр бий болсон арга хэмжээг хугацаанд нь ашиглалтад оруулж байгаа хэдий ч хөрөнгийг бүртгэх ажил удаашралтай байна.

V.1 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг ажлын гүйцэтгэлд үндэслэн хууль, журмын дагуу санхүүжүүлсэн байна.

⁴ 29.2.2.барилга байгууламжийн хувьд Барилгын тухай хуулийн 4.1.30-д заасан зураг төсөл болон сүүлийн хоёр жилийн хугацаанд хийгдсэн магадлалаар баталгаажсан төсөвтэй байх;

⁵ 3.2.2.2.барилга байгууламжийн хувьд сүүлийн 2 жилийн дотор хийгдсэн магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажсан зураг төсөл болон төсөвтэй байх;

⁶ 29.3.5.шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож, гурван жилд багтаан санхүүжүүлж, дуусгах;

⁷ 4.1.22."шалгуур үзүүлэлт" гэж хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн үе шат бүрд бий болох өөрчлөлтийг хэмжихээр төсөлд заасан тоон болон чанарын үзүүлэлтийг;

⁸ 4.1.23.“зорилтот түвшин” гэж бодлогыг хэрэгжүүлэх явцад болон хэрэгжиж дуусахад хүрэхээр хүлээгдэж байгаа өөрчлөлтийг төсөлд тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн тоон болон чанарын утгыг;

В.1.1 Төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа зарим төсөл, арга хэмжээ гэрээний хугацаанд хэрэгжээгүй, барилгын ажил зогсонги хэвээр байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд шинээр хэрэгжүүлэхээр батлагдсан эрх шилжиж ирсэн төсөл, арга хэмжээ байхгүй байна. Харин өмнөх оноос шилжсэн 4 төсөл, арга хэмжээг 8,495.6 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр анх гэрээ байгуулсан боловч ажлын явцад 2 төсөл, арга хэмжээний гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулан гэрээний дүнг 10,993.9 сая төгрөг болгон нэмэгдүүлжээ.

Хүснэгт 6: 2025 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний хэрэгжүүлэх хугацаа, хэрэгжсэн байдал, гэрээний дүн

Төсөл, арга хэмжээний нэр	Хугацаа		Хэрэгжиж дууссан эсэх	Гэрээний дүн	
	Эхлэх	Дуусах		Анхны	Сүүлийн
Төрийн нэг цэгийн үйлчилгээний төвийн барилга /Дундговь, Сайнцагаан сум/	2024	2025	Тийм	3,722.8	3,722.8
Соёлын төвийн барилга, 240 суудал /Дундговь, Цагаандэлгэр сум/	2019	2025	Үгүй	1,228.3	1,523.4
240 суудалтай Соёлын төвийн барилгын гадна инженерийн шугам сүлжээ, гадна талбайн тохижилтын угсралтын ажил /Дундговь, Цагаандэлгэр сум/	2024	2025	Тийм	751.9	751.9
Соёл, урлагийн цогцолборын барилга /Дундговь, Өндөршил сум/	2024	2026	Хугацаа болоогүй	2,792.6	4,995.8
Дүн	-	-	-	8,495.6	10,993.9

Эх сурвалж: Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтэс

Өмнөх оноос шилжин хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээнээс 2 барилга, байгууламжийн ажил гэрээнд заасан хугацаанд бүрэн хэрэгжиж, санхүүжилтийг 100 хувь олгосон.

Өндөршил сумын Соёл, урлагийн цогцолборын барилгын ажлын гүйцэтгэгчийг 2024 онд сонгон шалгаруулж, 2,792.6 сая төгрөгөөр “Цагаан шовх хайрхан” ХХК-тай ажил гүйцэтгэх гэрээг байгуулсан байна. Гүйцэтгэгч компани ажлын төсвийг шинэчлэн 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн 2028/2024 тоот магадлалын ерөнхий дүгнэлт, аудитын тайлан, дүгнэлтээр төсөв 4,995.8 сая төгрөг болж нэмэгдсэн байна. Засгийн газрын 2023 оны 489 дүгээр тогтоол, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2025 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 01/2355 тоот албан зөвлөмжийг үндэслэн Өндөршил сумын Соёл, урлагийн цогцолборын барилгын ажлын гүйцэтгэгч “Цагаан шовх хайрхан” ХХК-тай аймгийн Засаг дарга үнийн дүнг 2,203.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэн нэмэлт гэрээ байгуулсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2019 оноос хэрэгжиж эхэлсэн Цагаандэлгэр сумын 240 хүний суудалтай Соёлын төвийн барилгын ажлын гэрээний хугацааг 2 удаа сунган 2023 оны 07 дугаар сарын 30-ны өдөр барилгыг хүлээлгэн өгөхөөр нэмэлт гэрээ байгуулсан боловч гүйцэтгэгч байгууллагын үйл ажиллагаанаас шалтгаалан барилгын угсралтын ажил удааширсан ба 2023 оноос хойш ажил хийгдээгүй, гүйцэтгэл 75 хувьтай байна.

В.1.2 Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгосон байна.

Өмнөх оноос шилжин хэрэгжиж байгаа 4 төсөл, арга хэмжээнээс 2025 онд “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.8.38.3⁹-г заасны дагуу 3 ажлын гүйцэтгэлд үндэслэн 4,696.0 сая төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэгч болон хяналтад олгосон байна.

Хүснэгт 7: 2025 онд олгосон санхүүжилтийн мэдээлэл:

⁹ 4.8.38.3.санхүүжилтийн зохицуулалтыг тухайн төсөл, арга хэмжээний хэрэгжилт, гүйцэтгэлд үндэслэх;

Төсөл, арга хэмжээний нэр	Нийт гэрээний дүн	Санхүүжилт	
		Ажил эхэлснээс хойш олгосон	2025 онд олгосон
Төрийн нэг цэгийн үйлчилгээний төвийн барилга /Дундговь, Сайнцагаан сум/	3,722.8	3,722.8	1,786.2
Соёлын төвийн барилга, 240 суудал /Дундговь, Цагаандэлгэр сум/	1,523.4	1,135.2	-
240 суудалтай Соёлын төвийн барилгын гадна инженерийн шугам сүлжээ, гадна талбайн тохижилтын угсралтын ажил /Дундговь, Цагаандэлгэр сум/	751.9	739.0	739.0
Соёл, урлагийн цогцолборын барилга /Дундговь, Өндөршил сум/	4,995.8	2,170.8	2,170.8
Нийт дүн	10,993.9	7,767.8	4,696.0

Эх сурвалж: Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтэс

Сайнцагаан сумын “Төрийн нэг цэгийн үйлчилгээний төвийн барилга”-ын төсөл, арга хэмжээ нь 2024 оны эцэст 52.0 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж 1,936.7 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон бол тайлант онд 3 удаагийн ажлын гүйцэтгэлээр 1,786.2 санхүүжилтийг олгосон байна. Нийт 3,722.8 сая төгрөгийн санхүүжилтийн 87 хувь буюу 3,238.0 сая төгрөгийг барилга угсралтын ажлын хөлсөнд гүйцэтгэгч талд олгосон бол 2 хувийг захиалагчийн хяналтын зардалд, мөн 2 хувийг магадалшгүй ажлын зардалд, 1 хувийг зохиогчийн хяналтын зардалд тус тус зарцуулсан байна.

Харин Цагаандэлгэр сумын “Соёлын төвийн барилгын гадна инженерийн шугам сүлжээ, гадна талбайн тохижилт”-ын ажлыг 751.9 сая төгрөгөөр гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсан бөгөөд үүний 2 хувь болох 12.9 сая төгрөгийг магадалшгүй ажлын зардалд төсөвлөсөн. Гүйцэтгэгч байгууллагын зүгээс тайлант онд төсөл, арга хэмжээг гэрээний дагуу гүйцэтгэж дуусган ажлыг улсын комисст хүлээлгэн өгч санхүүжилтийг бүрэн авсан бол магадалшгүй ажлын зардал болох 12.9 сая төгрөгийн санхүүжилтийг хэмнэлтэд тооцон улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Өндөршил сумын “Соёл, урлагийн цогцолборын барилга”-ын ажил гэрээний дагуу ажлын гүйцэтгэл 43.5 хувьтай, 2025 онд олгохоор хуваарилагдсан 2,170.8 сая төгрөгийн санхүүжилтийг эрх нээлгэн гүйцэтгэлд үндэслэн бүрэн олгосон байна.

В.1.3 Тайлант онд хийгдсэн төсөл, арга хэмжээг ажлын даалгавар, зураг төсвийн дагуу гүйцэтгүүлсэн эсэхэд тухай бүрд хяналт тавьж ажилласан байна.

Барилга угсралтын ажил хийгдсэн 3 төсөл, арга хэмжээ бүрд захиалагчийн болон зохиогчийн хяналт хийж төсөл арга хэмжээг ажлын даалгавар, зураг төсвийн дагуу гүйцэтгүүлсэн эсэхэд захиалагчийн болон зохиогчийн хяналтыг тавьж ажилласан байна.

Сайнцагаан сумын “Төрийн нэг цэгийн үйлчилгээний төвийн барилга”-ын ажлын явцад нийтдээ 6 удаагийн хяналт шалгалт хийгдсэнээс тайлант онд 3 удаагийн зохиогчийн болон захиалагчийн хяналт хийж дүгнэлт, тайланг гаргасан байна. 2024 оны 9 дүгээр сард барилгын ажлын явцад зураг төсөлд тусгагдаагүй дулааны гадна шугам хуучирч, шаардлага хангахгүй байсан учир захиалагч, ашиглагч, хангагч тал болон гүйцэтгэгч талуудын төлөөллийн бүрэлдэхүүнтэй хурлын шийдвэрээр магадалшгүй ажлын 64.6 сая төгрөгөөр 99 м шугам сүлжээнд бүрэн шинэчлэлт хийсэн байна.

Цагаандэлгэр сумын “Соёлын төвийн барилгын гадна инженерийн шугам сүлжээ, гадна талбайн тохижилт”, Өндөршил сумын “Соёл, урлагийн цогцолборын барилга”-ын төсөл, арга хэмжээний ажлын явцад тус бүр 2 удаа зураг төсвийн дагуу ажил хийгдэж байгаа эсэхэд зохиогчийн болон захиалагчийн хяналтыг хийж, зөвлөх үйлчилгээний болон барилга угсралт, их засварын ажлын хяналтын хуудсанд үндэслэн санхүүжилтийг олгожээ.

В.1.4 Барилга угсралтын ажил хийгдээгүй, зогссон төсөл, арга хэмжээг дуусгахад анхаарч, холбогдох арга хэмжээг авч ашиглалтад оруулах шаардлагатай байна.

Тайлант онд гүйцэтгэж дууссан 2 төсөл, арга хэмжээний эцсийн буюу бүрэн санхүүжилтийг олгохдоо “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.8.29¹⁰-т заасны дагуу ажлын гэрээг дүгнэсэн байна. Тус гэрээ дүгнэсэн маягтад гэрээний биелэлтийг тооцохдоо тухайн барилга, байгууламжийг ашиглалтад оруулах улсын комиссын дүгнэлтийг үндэслэжээ.

Сайнцагаан сумын “Төрийн нэг цэгийн үйлчилгээний төвийн барилга”-ын ажлын гүйцэтгэгч тал гэрээнд заасан хугацаанд барилга, угсралтын ажлыг гүйцэтгэж, 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдөр барилга, байгууламжийг ашиглалтад оруулах комисс ажиллаж эхэлсэн боловч тус улсын комиссын гишүүдийн дүгнэлт баталгаажуулсан улмаас 2025 оны 10 дугаар сарын 22-ны өдөр хүртэл барилга хүлээн авах ажил удааширсан байна. Уг нөхцөл байдлыг гэрээ дүгнэсэн маягтад дурдсан бөгөөд төсөл, арга хэмжээг ажлын даалгавар, техникийн тодорхойлолт, зураг төсвийн дагуу бүрэн гүйцэтгэсэн гэж үзэж барилга, байгууламжийг ашиглалтад оруулах комиссын шийдвэрээр барилгыг хүлээн авсан байна.

Цагаандэлгэр сумын “Соёлын төвийн барилгын гадна инженерийн шугам сүлжээ, гадна талбайн тохижилт”-ын ажил гэрээний хугацаанд дуусаж, ГХБХБГ-ын даргын 2025 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/75 дугаар тушаалаар байгуулагдсан улсын комисс ажиллаж, ашиглалтад оруулахаар дүгнэлт гаргасан тул гэрээг дүгнэж үүргийн биелэлт хангагдсан гэж үзжээ.



Харин Цагаандэлгэр сумын 240 хүний суудалтай Соёлын төвийн барилгын ажлын хувьд тайлант онд гэрээг дүгнэн, барилга угсралтын ажлыг хугацаанд нь гүйцэтгээгүй буюу гэрээний үүргээ биелүүлээгүй гэж үзэн “Хэрмээдэй” ХХК-тай байгуулсан ажлыг гэрээг цуцалсан байна. Барилгын ажлыг дуусгахад 2019 онд батлагдсан төсвөөр гүйцэтгэх боломжгүй болсон тул хийгдээгүй ажлын тоо, хэмжээгээр төсвийг шинэчлэхээр төлөвлөжээ.

Иймд олон жил дамнан удааширсан Цагаандэлгэр сумын 240 хүний суудалтай Соёлын төвийн барилга, Цагаандэлгэр сумын Халуун ус, ахуй үйлчилгээний төвийн барилга, Эрдэнэдалай сумын Хатуу хучилттай авто замын ажлуудыг яаралтай дуусгах талаар холбогдох арга хэмжээг авч, ашиглалтад оруулах талаар анхаарч ажиллах шаардлагатай байна.

Энэ нь Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл хөтөлбөр хугацаандаа ашиглалтад орохгүй удааширнаар, төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг бууруулж, төлөвлөсөн арга хэмжээ үр дүнгүй болох сөрөг үр дагавартай байна.

В.2 Аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний хүрээнд 3 төсөл, арга хэмжээний барилга, байгууламжийн үе шат бүрд нийт 7 үдаагийн захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж, зардалд 101.8 сая төгрөгийг зарцуулсан байна.

В.2.1 Барилга, байгууламжийн үе шат бүрд зохиогчийн болон захиалагчийн техникийн хяналтыг хэрэгжүүлж, акт, фото зургаар баталгаажуулсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний эрх шилжиж ирээгүй, өмнөх оноос шилжиж ирсэн 4 төсөл, арга хэмжээ байна. Тайлант онд Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраас өмнөх оны АЗД-тай байгуулсан барилга, байгууламж, засварын ажилд захиалагчийн хяналт хийлгэх гэрээний хүрээнд Сайнцагаан сумын “Төрийн нэг цэгийн үйлчилгээний барилга”, Цагаандэлгэр сумын “240 суудалтай Соёлын төвийн барилгын гадна инженерийн шугам сүлжээ, гадна талбайн тохижилт угсралт”, Өндөршил сумын “Соёл, урлагийн цогцолборын барилга”-ын ажилд захиалагчийн хяналтыг хийж, тайлан, фото зургаар баримтжуулсан байна.

¹⁰ 4.8.29.Төсөл, арга хэмжээний эцсийн буюу бүрэн санхүүжилтийн хүсэлтэд гэрээг дүгнэсэн байх бөгөөд энэ журмын 16 дугаар хавсралтад заасан "Гэрээ дүгнэх маягт"-ыг үйлдэж баримт бичгийн иж бүрдэлд эх хувиар хавсаргаж ирүүлнэ

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраас 2025 онд захиалагчийн хяналтыг хийхдээ барилга байгууламжийн стандарт, засалд хяналт хэрэгжүүлж, хяналт хийсэн актыг үйлдэж, гүйцэтгэгч байгууллагаас дутуу хийгдсэн ажилд үүрэг даалгавар, шаардлага зөвлөмжийг өгч ажилласан байна.

Мөн Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулиар батлагдаж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагаа удааширснаас шалтгаалж, тухайн ондоо хийгдэж амжаагүй “Нэгдсэн эмнэлгийн мэс заслын вакуум өрөөний тохижилт, тоног төхөөрөмж”-ийн төсөл, арга хэмжээг 2025 онд хэрэгжүүлж улсын комисс хүлээн авч ашиглалтад оруулсан байна. Дээрх төсөл, арга хэмжээний захиалагчийн хяналтыг 2 удаа хийж, тайлан, фото зургаар баримтжуулж ажилласан байна.

Хүснэгт 8: Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд тусгагдсан шилжих төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн байдал

№	Төсөл, арга хэмжээний нэр	Захиалагчийн хяналт хийсэн тоо	Техник хяналтын зардал /сая төгрөгөөр/
1	Соёл, урлагийн цогцолборын барилга /Дундговь, Өндөршил сум/	2	37.3
2	Соёлын төвийн барилга, 240 суудал /Дундговь, Цагаандэлгэр сум/	-	-
3	240 суудалтай Соёлын төвийн барилгын гадна инженерийн шугам сүлжээ, гадна талбайн тохижилтын угсралтын ажил /Дундговь, Цагаандэлгэр сум/	2	6.0
4	Төрийн нэг цэгийн үйлчилгээний төвийн барилга /Дундговь, Сайнцагаан сум/	3	58.5
	Нийт дүн	7	101.8

Эх сурвалж: Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар

Захиалагчийн хяналтыг тайланд онд давхардсан тоогоор 7 удаа хийж, техник хяналтын зардалд 101.8 сая төгрөгийг зарцуулжээ.

Эдгээр 4 төсөл, арга хэмжээнээс Сайнцагаан сумын “Төрийн нэг цэгийн үйлчилгээний барилга”, “240 суудалтай Соёлын төвийн барилгын гадна инженерийн шугам сүлжээ, гадна талбайн тохижилт угсралт”-ын ажил хэрэгжиж дууссан байна.

Өндөршил сумын Соёл, урлагийн цогцолборын барилгын ажлын гүйцэтгэгч “Цагаан шовх хайрхан” ХХК барилгыг 2026 онд 05 сард ашиглалтад өгөхөөр гэрээ байгуулж, барилгын ажил хэвийн явагдаж байна. Цагаандэлгэр сумын “Соёлын төвийн барилга”-ын ажил удаашралтай ажлын гүйцэтгэл 74 хувьтай, 2025 онд ажил хийгдээгүй, захиалагч гэрээг дүгнэж цуцлах дүгнэлт гарсан тул захиалагчийн хяналтыг хийгээгүй байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, гүйцэтгэл, үр дүнд хяналт, шалгалт хийгээгүй байна.

Иймд Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 5.1.3¹¹, 5.2.4¹²-д заасны дагуу төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, гүйцэтгэлд хяналт, шалгалт хийж, үнэлэлт, дүгнэлт өгч ажиллах нь зүйтэй байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 04 тоот захирамжаар Улсын төсвийн 2025 онд хийгдсэн хөрөнгө оруулалтад хяналт тавих ажлын хэсэг байгуулсан байна. Уг ажлын хэсэгт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа 4 төсөл, арга хэмжээнд хяналт хийж зөвлөгөө өгч ажилласан байна.

В.2.2 Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар болон зохиогчоос барилга байгууламжийн бетоны бат бэх, өрлөгийн ажлын стандарт, заслын ажлын материалын шаардлагад хяналт хэрэгжүүлж, үүрэг даалгавар өгч ажилласан байна.

¹¹ 5.1.3. төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа үйл ажиллагаа болон төсвийн санхүүжилт, зарцуулалт, түүний үр ашигтай байдал;

¹² 5.2.4. төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт, зарцуулалт, түүний үр ашгийн байдалд хяналт тавих;

Засгийн газрын 2017 оны 6 дугаар сарын 14-ны өдрийн 170 дугаар тогтоолоор баталсан "Барилгын ажлын захиалагчийн дүрэм"-д зааснаар захиалагч барилгын үе шатны ажлын гүйцэтгэлийн тэмдэглэл, ил далд ажил болон тоног төхөөрөмжийн туршилт, тохируулга хийсэн акт, санхүүжилт зэрэг бусад баримт бичгийг барилгын ажил гүйцэтгэх төлөвлөгөө, гэрээнд заасны дагуу барилгын үйл ажиллагаанд оролцогчидтой хамтран сар бүр хянан баталгаажуулна гэжээ.



Өндөршил сумын Соёл, урлагийн цогцолборын барилга угсралтын ажлын явцад “ЭМ ЭМ ИНЖЕНЕРИНГ” ХХК барилгын ажлын явцад зохиогчийн хяналт хийх №3Х-УТ2403401124/СОЯ20240101003 дугаартай 2024 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн барилгын зураг төслийн гэрээг 23.7 сая төгрөгийн санхүүжих дүнгээр 6 удаа хяналт хэрэгжүүлэхээр хийж, 2025 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын 15.1.1.1 батлагдсан өртгийн нэмэгдсэн дүн болох 18.9 сая төгрөгийг нэмж 2026 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр зохиогчийн хяналтад нэмэлт гэрээг аймгийн Засаг даргатай байгуулсан байна.

Цагаандэлгэр сум “240 суудалтай барилгын гадна инженерийн шугам сүлжээ, гадна талбайн тохижилтын угсралт”-ын ажилд “Өлзий-Иш” ХХК зохиогчийн хяналтыг хэрэгжүүлэхээр аймгийн Засаг даргатай гэрээ байгуулжээ. Гэрээг 2025 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн №3Х-УТ2003400753-ДУАХААГ/20240101055/ тоот барилгын гадна тохижилт, гадна шугам сүлжээний ажлын явцад зохиогчийн хяналтыг гэрээний дагуу 3 удаа хийж, дутуу ажил дээр үүрэг даалгавар зөвлөмж өгч ажилласан байна.

Хүснэгт 9: Зохиогчийн хяналтыг хэрэгжүүлсэн байдал

№	Дэд төсөл, арга хэмжээний нэр	Зохиогчийн хяналт хэрэгжүүлэгч	Зохиогчийн хяналт хэрэгжүүлэгчтэй гэрээ хийсэн эсэх	Хяналт хэрэгжүүлэх тоо	Зохиогчийн хяналтын тайлан	Гэрээний дүн	2025 онд олгосон санхүүжилт
1	Соёл, урлагийн цогцолборын барилга /ӨШ/	Эм Эм инженеринг	Тийм	2	2	42.6	18.6
2	Соёлын төвийн барилга, 240 суудал /ЦД/	Өлзий иш ХХК	Тийм			10.3	-
3	240 суудалтай Соёлын төвийн барилгын гадна инженерийн шугам сүлжээ, гадна талбайн тохижилтын угсралтын ажил /ЦД/	Өлзий иш ХХК	Тийм	3	3	3.0	3.0
4	Төрийн нэг цэгийн үйлчилгээний төвийн барилга /СЦ/	Автор ХХК	Тийм	5	5	32.3	29.1
	Нийт			10	10	88.2	50.7

Эх сурвалж: Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар

Зохиогчийн хяналтыг тайланд онд давхардсан тоогоор 10 удаа хийж, зохиогчийн хяналтын зардалд 50.7 сая төгрөгийг зарцуулжээ.

Цагаандэлгэр сумын 240 суудалтай Соёлын төвийн барилгын гадна инженерийн шугам сүлжээ, гадна талбайн тохижилтын угсралтын ажил, Сайнцагаан сумын Төрийн нэг цэгийн үйлчилгээний төвийн барилгын ажлын барилга байгууламжийн бетоны бат бэх, өрлөгийн ажлын стандарт, заслын ажилд Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар болон зохиогчоос хяналтыг гэрээний дагуу хэрэгжүүлж, тайлан мэдээг гаргасан байна. Өндөршил сумын Соёл, урлагийн цогцолбор барилгын ажил 2026 онд ажил дуусах гэрээтэйгээр ажил явагдаж зохиогчийн хяналтыг 2 удаа хийсэн байна. Харин Цагаандэлгэр сумын 240 суудалтай Соёлын төвийн барилгын ажил зогссон тул зохиогчийн хяналтыг хийгээгүй байна.

В.2.3 Гэрээний хугацаанд дууссан төсөл, арга хэмжээг комисс заавар журмын дагуу хяналт тавьж ашиглалтад хүлээн авсан байна.

Улсын төсвийн хөрөнгөөр 2024 оноос хэрэгжиж эхэлсэн 751.8 сая төгрөгийн гэрээний дүнтэй Цагаандэлгэр сумын “240 суудалтай Соёлын төвийн барилгын гадна инженерийн шугам сүлжээ,



гадна талбайн тохижилт”-ын төсөл, арга хэмжээний ажил гэрээний хугацаанд дуусгасан байна. “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-д заасны дагуу Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын 2025.12.22-ны өдрийн А/75 тоот тушаалаар томилогдсон комиссын 2025.12.24-ний өдрийн дүгнэлтээр ашиглалтад хүлээн авсан байна. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дүгнэлтээр гишүүд дүрмийн 4 дүгээр хавсралтын дагуу барилга, байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үүрэг

даалгаврын биелэлтийн хуудсанд санал дүгнэлт, үүрэг даалгаврыг өгч хурлын тэмдэглэлээр баталгаажуулсан байна. Комиссоос дараах санал дүгнэлт, үүрэг даалгавар өгснийг хэрэгжүүлж ажилласан байна. Үүнд:

- Огтолгоо авсан дулааны худаг цэвэрлэх
- Гадна шугам газрын тэгшилгээг сайжруулж, тэгш байдлыг хангах
- Гүйцэтгэлийн баримтын эх хувийг Төрийн архивд хүлээлгэн өгөх
- Баримт материалыг цахимаар хадгалуулах
- Хамгаалалтын хайрцагт хийх
- Магадалшгүй ажлын хурлын шийдвэр, төсөв актыг гарган ирүүлэх
- Гүйцэтгэлийн баримт бичгийг 4 хувь үйлдэх
- Өмч хөрөнгийн задаргааг гарган Орон нутгийн өмчийн газарт хүргүүлэх
- Төмөр багана тулгуураас шилэн кабелийг салгаж, тусад нь тулгуурлан бэхлэх;

Мөн улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн 3,722.8 сая төгрөгийн гэрээний дүнтэй Сайнцагаан сумын “Төрийн нэг цэгийн үйлчилгээний барилга”-ын ажлыг Газрын харилцаа, барилга, хот



байгуулалтын газрын даргын 2025.04.07-ны өдрийн А/13 тоот тушаалаар байгуулагдсан 17 хүний бүрэлдэхүүнтэй комиссын 2025.05.07-ны өдрийн барилга, байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт, өгсөн үүрэг даалгаврын биелэлтээр хүлээн авсан байна.

Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 278 дугаар тогтоолын 16 дугаар хавсралтаар гэрээ дүгнэх маягтын гэрээний биелэлтийн дагуу комиссын гишүүдийн барилга хүлээлгэн өгөх дүгнэлт баталгаажиж, үүрэг даалгаврын биелэлт хангагдсан боловч зураг төсвийн үнийг бүрэн төлөөгүй шалтгаанаар төсөл зохиогч нь саналын хуудсанд гарын үсэг зураагүйгээс уг барилгын ашиглалтад оруулах явц удааширч 2025 оны 05 дугаар сарын 7-ны өдрөөс 2025 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн хооронд 3 удаа комисс ажиллаж барилгыг хүлээж авсан байна.

В.2.4 Барилга байгууламжийн төсөл, арга хэмжээний мэдээллийн самбарыг стандартын дагуу хийж байршуулж, олон нийтэд ил тод мэдээлэх ажил бүрэн хэрэгжээгүй байна.

Монгол Улсын үндэсний стандартад /MNS 7023:2023/ заасны дагуу улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжих инженерийн барилга байгууламжийн барилгын ажил, гадна тохижилтын ажил бусад бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээнд хэрэглэх мэдээллийн самбар байршуулах, тэдгээрийн нэгдсэн загвар, аргачлалыг Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн С/49 дүгээр тушаал баталсан байна. Дээрх аргачлалын дагуу Өндөршил сумын Соёл, урлагийн цогцолборын барилын ажлыг Цагаан шовх хайрхан ХХК, Цагаандэлгэр сумын “240 суудалтай Соёлын төвийн барилгын гадна инженерийн шугам сүлжээ, гадна талбайн тохижилт угсралт”-ын ажлыг



Мандал шилтгээн ХХК тус тус гүйцэтгэж, барилга угсралт, шугам сүлжээ, гадна талбайн тохижилтын ажлын мэдээллийн самбарыг стандартад тавигдах шаардлагын дагуу байршуулж, олон нийтэд ил тод мэдээлсэн байна. Харин Сайнцагаан сумын “Төрийн нэг цэгийн үйлчилгээний барилга”, Цагаандэлгэр сумын “Соёлын төвийн барилга”-ын ажилд мэдээллийн самбар байршуулаагүй байна.



Энэ нь Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.2 дэх хэсэг, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6.¹⁰, 8.6.¹¹-д заасны дагуу барилга байгууламж болон үйл ажиллагааныхаа талаарх иж бүрэн мэдээллийг тухайн нутаг дэвсгэрт нийтэд ил тод байрлуулах заалтыг зөрчиж байна.

Иймд улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээнд хэрэглэх мэдээллийн самбарыг холбогдох стандарт, норм, дүрмийн дагуу байршуулсан эсэхэд захиалагч хяналт тавих шаардлагатай байна.

В.3 Өмнөх онуудад улсын төсвийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийг төрийн болон орон нутгийн өмчид бүртгэх ажил удаашралтай байна.

В.3.1 Тайлант онд төсвийн хөрөнгөөр бий болсон төсөл, арга хэмжээний хөрөнгийг холбогдох газарт бүртгүүлэхээр уламжилж, ашиглалтад орсон хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаж байна.

Тайланд онд хэрэгжиж дууссан Нэгдсэн эмнэлгийн “Мэс заслын вакуум өрөөний тохижилт, тоног төхөөрөмж”-төсөл арга хэмжээний 1,366.4 сая төгрөгийн хөрөнгийг машин, тоног төхөөрөмж дансанд, Цагаандэлгэр сумын “240 суудалтай Соёлын төвийн барилгын гадна инженерийн шугам сүлжээ, гадна талбайн тохижилтын угсралт”-ын 751.8 сая төгрөгийн хөрөнгийг Цагаандэлгэр сумын Соёлын төвийн үндсэн хөрөнгийн дансанд тус тус бүртгэсэн байна.

Харин Сайнцагаан сумын “Төрийн нэг цэгийн үйлчилгээний төвийн барилга”-ыг 3,722.8 сая төгрөгийн барилгыг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэхээр 2025 оны 12 сарын 26-ны 878 тоот тогтоолоор Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас шийдвэрийг гаргуулж, Орон нутгийн өмчийн газраас аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тус хөрөнгийг бүртгүүлэхээр албан бичиг хүргүүлсэн байна.

Дээрх улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн “Төрийн нэг цэгийн үйлчилгээний төвийн барилга” болон Нэгдсэн эмнэлгийн “Мэс заслын вакуум өрөөний тохижилт, тоног төхөөрөмж”-ийг бүрэн хүчин чадлаар зориулалтын дагуу ашиглагдаж байна.

В.3.2 Төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг бодлогын баримт бичигт тусгасан зорилтод түвшинд тайлагнаж байна.

Дундговь аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталсан Сайнцагаан сумын “Төрийн нэг цэгийн үйлчилгээний барилга”, Цагаандэлгэр сумын 240 суудалтай Соёлын төвийн барилгын гадна инженерийн шугам сүлжээ, гадна талбайн тохижилт угсралт”-ын төсөл, арга хэмжээний шалгуур үзүүлэлтийг барилгын ажлын гүйцэтгэл болон баригдсан барилга, байгууламжийн тоогоор хэмжихээр төлөвлөж, бодлогын баримт бичигт тусгасан зорилтод хүрсэн байна. Өндөршил сумын “Соёл, урлагийн цогцолборын барилга”-ын ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөж, барилгын ажил хэвийн явагдаж байна.



Харин өмнөх жилүүдэд бодлогын баримт бичигт тусгагдсан Цагаандэлгэр сумын 240 суудалтай Соёлын төвийн барилгын ажил бүрэн хэрэгжээгүй байна.

Иймд бодлогын баримт бичигт тусгагдсан арга, хэмжээг бүрэн хэрэгжүүлж, хөрөнгө оруулалтаас иргэдийн хүртэх хүртээмжийг дээшлүүлж, үр өгөөжийг сайжруулах ажлыг зохион байгуулах шаардлагатай байна.

В.3.4 Өмнөх аудитаар тогтоосон акт, албан шаардлага, өгсөн зөвлөмжийг хэрэгжилт 71.4 хувьтай байна.

Өмнөх аудитаар Аймгийн Засаг дарга, Орон нутгийн өмчийн газарт нийт 3 заалт бүхий зөвлөмж, 3 албан шаардлага, хууль хяналтын байгууллагат шилжүүлэх 1 албан шаардлагын хэрэгжилтийг тулган шалгахад аймгийн Засаг даргад өгсөн 3 зөвлөмж, хууль хяналтын байгууллагат шилжүүлэх 1 албан шаардлагын хэрэгжилтийг биелүүлсэн байна.

Харин Орон нутгийн өмчийн газарт өгсөн “Наадмын талбайн дуусгал” ажлын үнийн зөрүүг Төрийн өмчийн хорооны шийдвэр гараагүй шалтгаанаар тус газрын үндсэн хөрөнгийг, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон Гудамж, талбайн тохижилт, ногоон байгууламж /Дундговь/, Ноос хяргах байгууламж, тоног төхөөрөмж /Дундговь, Хулд сум/-ийн төсөл, арга хэмжээг орон нутгийн хөрөнгөд бүртгээгүй гэсэн 2 албан шаардлагын хэрэгжилт биелээгүй байна.

Албан шаардлагыг хэрэгжилтийг биелүүлээгүй шалтгааныг Орон нутгийн өмчийн газраас тодруулахад аймгийн Биеийн тамир, спортын газрын үндсэн хөрөнгөд бүртгэгдэх “Наадмын талбайн дуусгал”, Хулд сумын Ноос хяргах байгууламж, тоног төхөөрөмжийн хувьд үндсэн хөрөнгөд бүртгэгдэх ажлын үнийн зөрүүг гүйцэтгэгч компаниар тус тус хөрөнгийн задаргааг хийлгэж, гаргуулахаар тус гүйцэтгэгч компанид хандсан боловч хөрөнгийн задаргааг гаргаж өгөх боломжгүй гэсэн хариу ирүүлсэн тул уг хөрөнгийг данс, бүртгэлд бүртгэж аваагүй байна.

Цаашид хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалтад тавих хяналт суларч, хөрөнгө үрэгдэх, шамшигдах үр дагавартай байна.

Иймд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний үр дүнд бий болсон, хөрөнгө оруулалтыг хүлээн авах комиссын шийдвэр гарсан даруй баримт материалыг бүрдүүлэн шийдвэр гаргагч эрх бүхий байгууллагад хүргүүлэн ашиглагч байгууллагын холбогдох дансанд бүртгэж хэвших нь зүйтэй байна.



Дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл, арга хэмжээг хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдуулан, бодит нөхцөл байдлыг үнэлж, хэрэгцээ шаардлагаар эрэмбэлж хэрэгжүүлэх шаардлагатай байна;
2. Шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний саналд үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэр зэрэг холбогдох тооцоог хийж хэвших шаардлагатай байна;
3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналд төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл хүргүүлэх нь орон нутгийн иргэдийн хөрөнгө оруулалтаас хүртэх нийгэм, эдийн засгийн эерэг боломжийг бууруулах эрсдэлтэй байна;
4. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг ажлын гүйцэтгэлд үндэслэн хууль, журмын дагуу санхүүжүүлсэн байна;
5. Барилга угсралтын ажил хийгдээгүй, зогссон төсөл, арга хэмжээг дуусгахад анхаарч, ашиглалтад оруулах шаардлагатай байна;
6. Гэрээний хугацаанд дууссан төсөл, арга хэмжээг комисс заавар журмын дагуу хяналт тавьж ашиглалтад хүлээн авсан байна;
7. Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар болон зохиогчоос барилга байгууламжийн бетоны бат бэх, өрлөгийн ажлын стандарт, заслын ажлын материалын шаардлагад хяналт хэрэгжүүлж, үүрэг даалгавар өгч ажилласан байна;
8. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээнд хэрэглэх мэдээллийн самбарыг холбогдох стандарт, норм, дүрмийн дагуу байршуулсан эсэхэд захиалагч хяналт тавих шаардлагатай байна;
9. Өмнөх аудитаар тогтоосон акт, албан шаардлага, өгсөн зөвлөмжийг хэрэгжилт 71.4 хувьтай байна;



Зөвлөмж

Аудитын нотлох баримт, аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна.

Аймгийн Засаг даргад:

- 1. Бүрэн хэрэгжиж дуусаагүй Цагаандэлгэр сумын 240 хүний суудалтай Соёлын төвийн барилга, Цагаандэлгэр сумын Халуун ус, ахуй үйлчилгээний төвийн барилгын төсөл, арга хэмжээг дуусган, ашиглалтад оруулж, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг сайжруулах;*
- 2. Барилга байгууламжийн төсөл, арга хэмжээний мэдээллийн самбарыг стандартын дагуу байршуулж, олон нийтэд ил тод мэдээлэхэд хяналт тавих;*
- 3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн “Наадмын талбайн дуусгал”, “Гудамж, талбайн тохижилт, ногоон байгууламж”, Хүлд сумын “Ноос хяргах байгууламж, тоног төхөөрөмж” төсөл, арга хэмжээгээр бий болсон хөрөнгийг ашиглагч байгууллагын дансанд бүртгүүлж хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалтыг сайжруулах ажлыг зохион байгуулан, хяналт тавьж ажиллах;*



Шалгагдагч байгууллагын санал тайлбар



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА**

С.Баянзүхийн өргөн чөлөө 2-211 тоот, 7 дугаар баг
Сайнцагаан сум, Дундговь аймаг, 48090 Утас: 7059 2353
Цахим шуудан: info@dundgovi.gov.mn,
Цахим хуудас: www.dundgovi.gov.mn

2026.04.06 № 01/525
танай _____ -ны № _____ -т

**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

2025 онд хэрэгжсэн Улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн аудитын тайланд дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

- Эрдэнэдалай сумын хатуу хучилттай авто замын ажлын баримт бичиг болон гүйцэтгэгч компанийн мэдээллийг шүүх хяналтын байгууллагад хүргүүлсэн. Тус ажлын төсвийг шинэчлүүлэхээр “Классик роуд” ХХК-тай гэрээ байгуулж, барилга хөгжлийн төвд хүсэлт гаргасан талаар тайланд тусгуулах.

- 2025 оны төсвийн хуульд батлагдаагүй ажилтай холбоотой хэсгийг тайлангаас хасуулах.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ Ц.АРИУНБАЯР



4826240243

Дундговь аймгийн Засаг даргаас ирүүлсэн тайлбарт хариу өгөх Аудитын газрын тайлбар:

Тайлбар-1	<p>Тайлангийн төсөлд санал ирүүлсэн албан бичгийн нотлох баримтыг судлаад дараах байдлаар шийдвэрлэлээ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Эрдэнэдалай сумын хатуу хучилттай авто замын ажлын талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний нотлох баримтыг ирүүлсэн тул санал тайлбарыг хүлээн авч асуудлын бүртгэлээс хасаж шийдвэрлэлээ. 2. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд тусгагдаагүй, удаашралтай байгаа бусад барилга, байгууламжийг ашиглалтад оруулахтай холбоотой эрх үүрэг аймгийн Засаг даргад шилжиж ирсэн тул саналыг хүлээх авах боломжгүй болно. Иймд зөрчлийг хэвээр үлдээж, зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэлээ.
------------------	--

Хавсралт №1. Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчаас улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр хүргүүлсэн төсөл, арга хэмжээний саналын бодлогын баримт бичигтэй уялдсан байдал

№	Төсөл, арга хэмжээний нэр	Сум	2025 оны хөгжлийн төлөвлөгөө		2021-2025 үндсэн чиглэл		2020-2024 оны ЗДҮАХ		2024-2028 оны ЗДҮАХ	
			Тусгагдсан эсэх	Заалтын дугаар	Тусгагдсан эсэх	Заалтын дугаар	Тусгагдсан эсэх	Заалтын дугаар	Тусгагдсан эсэх	Заалтын дугаар
1	Дулааны станцын 2-р хэлхээний гадна дулааны шугамын ажил /Дундговь, Сайнцагаан сум/	Сайнцагаан	Үгүй	-	Тийм	4.2.2.3	Тийм	3.5.1.3	Тийм	1.1.2.5
2	Дотуур байрны барилга, 80 ор /Дундговь, Адаацаг/	Адаацаг	Тийм	7	Тийм	2.1.2.1	Тийм	2.3.2.2	Тийм	3.1.1.7
3	Аймгийн төвийн 6.4 км үерийн хамгаалалтын далангийн барилга, байгууламжийн угсралтын ажлыг үргэлжлүүлэх /Дундговь, Сайнцагаан сум/	Сайнцагаан	Үгүй	-	Тийм	2.4.1.2	Тийм	6.1.1.10	Тийм	1.1.2.8
4	Засаг даргын Тамгын газрын барилга /Дундговь, Дэрэн сум/	Дэрэн	Тийм	93	Үгүй	-	Тийм	6.1.1.7	Тийм	2.1.1.4
5	Эрүүл мэндийн төвийн барилга, 10 ор /Дундговь, Дэрэн сум/	Дэрэн	Үгүй	-	Үгүй	-	Тийм	2.1.3.1.1	Тийм	3.2.1.8
6	Соёлын төв, хүүхдийн театрын барилга, 400 суудал /Дундговь, Сайнцагаан сум/	Сайнцагаан	Үгүй	-	Тийм	1.1.1.1 , 1.1.1.3	Тийм	2.5.1.1 , 2.5.1.3	Тийм	3.4.1.1 , 3.4.1.2
7	Олгойн говийн цэвэр усны 3.5 км дан цэвэр усны шугамыг хос болгох ажил	Сайнцагаан	Тийм	76	Үгүй	-	Үгүй	-	Үгүй	-
8	Цэцэрлэгийн барилга, 150 суудал /Дундговь, Хулд сум/	Хулд	Тийм	2	Тийм	2.1.1.1	Тийм	2.3.1.1	Тийм	3.1.1.7

Хавсралт №2. Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчаас улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр хүргүүлсэн төсөл, арга хэмжээний саналын шалгуур хангасан байдал

№	Төсөл, арга хэмжээний нэр	Сум	Төсвийн ерөнхийлөн захирагч	Төсөвт өртөг /Сая төгрөгөөр/	2025 оны УТХО-аар хэрэгжүүлэхээр батлагдсан эсэх	Магадлалын ерөнхий дүгнэлтээр хянагдсан байдал			
						Магадлалаар хянагдсан төсөв /Төгрөгөөр/	Магадлалын дүгнэлттэй эсэх	Огноо	Дугаар
1	Дулааны станцын 2-р хэлхээний гадна дулааны шугамын ажил /Дундговь, Сайнцагаан сум/	Сайнцагаан	Эрчим хүчний сайд	43,000.0	Үгүй	47,705,230,548.0	Тийм	2024.11.21	1016/2024
2	Дотуур байрны барилга, 80 ор /Дундговь, Адаацаг/	Адаацаг	Боловсрол, шинжлэх ухааны сайд	3,000.0	Үгүй		Байхгүй		
3	Аймгийн төвийн 6.4 км үерийн хамгаалалтын далангийн барилга, байгууламжийн угсралтын ажлыг үргэлжлүүлэх /Дундговь, Сайнцагаан сум/	Сайнцагаан	Барилга, хот байгуулалтын сайд	10,000.0	Үгүй	6,518,272,975.0	Тийм	2025	1346/2025
4	Засаг даргын Тамгын газрын барилга /Дундговь, Дэрэн сум/	Дэрэн	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга	2,272.3	Үгүй	2,273,270,507.0	Тийм	2021.06.29	845/2021
5	Эрүүл мэндийн төвийн барилга, 10 ор /Дундговь, Дэрэн сум/	Дэрэн	Эрүүл мэндийн сайд	3,000.0	Үгүй	3,297,285,573.0	Тийм	2021.06.28	234/2021
6	Соёлын төв, хүүхдийн театрын барилга, 400 суудал /Дундговь, Сайнцагаан сум/	Сайнцагаан	Соёлын сайд	11,057.0	Үгүй	11,056,777,949.0	Тийм	2021.12.10	1987/2021
7	Олгойн говийн цэвэр усны 3.5 км дан цэвэр усны шугамыг хос болгох ажил	Сайнцагаан	Барилга, хот байгуулалтын сайд	1,804.0	Үгүй	1,804,215,380.0	Тийм	2023.03.31	351/2023
8	Цэцэрлэгийн барилга, 150 суудал /Дундговь, Хулд сум/	Хулд	Боловсрол, шинжлэх ухааны сайд	2,589.6	Үгүй	2,589,594,250.0	Тийм	2023.01.27	0097/2023
	Нийт			76,722.9		75,244,647,182.0			

Монгол Улс, Дундговь аймаг 48090, Сайнцагаан сум, Нарлаг
баг, Нутгийн удирдлагын ордон Утас/Факс: 70-59-24-39
E-mail: dundgovi@audit.gov.mn ОН